

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/178/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Назгүл
Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	15
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт	20
5.2 Албан шаардлага.....	20
5.3 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА А.ГАЛИЯ ТАНАА

2023.02.07 № 25
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан, баталж ажиллаагүй байна.

Аудитын гол асуудал

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

ХХҮГ Дүгнэлт-2.04-ТА

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



ХХҮГ Дүгнэлт-2.04-ТА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,244,128.76</u>	<u>5394417.76</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	0.00
33	АВЛАГА	102,711.00	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	102,711.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5,141,417.76	5394417.76
354	Хангамжийн материал	5,141,417.76	5394417.76
35420	Аж ахуйн материал	3,953,599.95	4206599.95
35470	Бусад хангамжийн материал	1,187,817.81	1187817.81
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>197,870,458.65</u>	<u>179165659.83</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	197,870,458.65	179165659.83
392	Биет хөрөнгө	173,213,792.01	161395659.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	102,689,570.00	102689570.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(7,146,353.52)	-9042846.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	117,644,160.00	117644160.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(117,644,160.00)	-117644160.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	170,664,577.07	179899377.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	(103,082,347.65)	-120091185.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,292,697.54	31490697.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,082,501.43)	-24428102.87
39217	Ном	878,150.00	878150.00
393	Биет бус хөрөнгө	24,656,666.64	17770000.04
39301	Програм хангамж	15,080,000.00	15080000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,993,333.36)	-9879999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	12,570,000.00	12570000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	<u>203,114,587.41</u>	<u>184560077.59</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,062,104.00</u>	<u>0.00</u>

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,062,104.00	0.00
413	Өглөг	1,062,104.00	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,062,104.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	202,052,483.41	184560077.59
51	Засгийн газрын хувь оролцоо	202,052,483.41	184,560,077.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	366,556,926.98	366,556,926.98
51101	Өмч: - төрийн	366,556,926.98	366556926.98
512	Хуримтлагдсан үр дүн	(428,129,890.63)	-445622296.45
51210	Өмнөх үеийн үр дүн	(402,573,657.79)	-428129890.63
51220	Тайлант үеийн үр дүн	(25,556,232.84)	-17492405.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	263,625,447.06	263625447.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	203,114,587.41	184560077.59

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	709,556,666.40	730,167,640.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	709,556,666.40	730,167,640.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	690,441,666.40	677,973,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	679,612,000.00	668,738,400.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	10,829,666.40	9,234,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,115,000.00	52,194,440.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,000,000.00	52,094,440.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,115,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	734,886,482.83	747,660,045.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	734,886,482.83	747,660,045.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	702,246,282.83	724,993,597.82

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	526,291,993.00	563,358,899.00
210101	Үндсэн цалин	382,917,023.00	405,563,877.00
210102	Нэмэгдэл	124,873,270.00	139,457,404.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,501,700.00	15,995,200.00
210104	Урамшуулал	-	2,342,418.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,680,000.00	71,409,000.00
210201	Тэтгэврийн даатгал	53,071,100.00	49,801,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,152,200.00	5,401,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,121,800.00	4,321,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,030,400.00	1,080,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,304,500.00	10,804,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,649,000.00	36,284,100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,849,000.00	1,484,100.00
210304	Байрны түрээс	34,800,000.00	34,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,366,900.00	18,704,300.00
210401	Бичиг хэрэг	8,247,450.00	8,729,100.00
210402	Тээвэр, шатахуун	6,017,700.00	7,048,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,189,550.00	1,286,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,912,200.00	1,639,900.00
2105	Нормативт зардал	1,067,000.00	-
210502	Хоол, хүнс	1,067,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,443,400.00	1,146,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,443,400.00	1,146,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,294,100.00	3,776,000.00
210702	Дотоод албан томилолт	1,294,100.00	3,776,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,570,800.00	2,176,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,250,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	321,700.00	270,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,700.00	108,200.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	33,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	830,800.00	1,764,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,883,089.83	28,137,598.82
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,883,089.83	28,137,598.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,640,200.00	22,666,448.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,640,200.00	730,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,855,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	785,200.00	730,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	21,695,808.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		21,695,808.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	240,440.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		240,440.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(25,329,816.43)	(17,492,405.82)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	226,416.41	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	226,416.41	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(226,416.41)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(25,556,232.84)	(17,492,405.82)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	698,727,000.00	720932840.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	698,727,000.00	720932840.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	679,612,000.00	668738400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	679,612,000.00	668738400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,115,000.00	52194440.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		100000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,000,000.00	52094440.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,115,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	698,158,000.00	720734840.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	698,158,000.00	720734840.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	665,517,800.00	698068392.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	525,332,600.00	564318292.00
210101	Үндсэн цалин	381,957,630.00	406523270.00
210102	Нэмэгдэл	124,873,270.00	139457404.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,501,700.00	15995200.00
210104	Урамшуулал		2342418.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,680,000.00	71409000.00
210201	Тэтгэврийн даатгал	53,071,100.00	49801200.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,152,200.00	5401700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,121,800.00	4321600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,030,400.00	1080100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,304,500.00	10804400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,649,000.00	36284100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,849,000.00	1484100.00
210304	Байрны түрээс	34,800,000.00	34800000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,509,300.00	18957300.00
210401	Бичиг хэрэг	8,287,100.00	8729100.00
210402	Тээвэр, шатахуун	6,017,700.00	7048800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,123,400.00	1286500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,081,100.00	1892900.00
2105	Нормативт зардал	1,067,000.00	0.00
210502	Хоол, хүнс	1,067,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,443,000.00	1146800.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	1,443,000.00	1146800.00
2107	Томилолт, зочны зардал	1,294,100.00	3776000.00
210702	Дотоод албан томилолт	1,294,100.00	3776000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,542,800.00	2176900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,250,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	321,700.00	270400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,700.00	108200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	33500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	802,800.00	1764800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,640,200.00	22666448.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,640,200.00	730200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,855,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	785,200.00	730200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	21695808.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		21695808.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	240440.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		240440.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>569,000.00</u>	<u>198000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	569,000.00	198000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	569,000.00	198000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	569,000.00	198000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	569,000.00	198000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(569,000.00)</u>	<u>-198000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	366,556,926.98	263,625,447.06	-361,731,100.78	268,451,273.26
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	366,556,926.98	263,625,447.06	-361,731,100.78	268,451,273.26
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-66,398,789.85	-66,398,789.85
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,556,926.98	263,625,447.06	-428,129,890.63	202,052,483.41
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	366,556,926.98	263,625,447.06	-428,129,890.63	202,052,483.41
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	366,556,926.98	263,625,447.06	-428,129,890.63	202,052,483.41
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-17,492,405.82	-17,492,405.82
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,556,926.98	263,625,447.06	-445,622,296.45	184,560,077.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	696,134,000.00	647,042,592.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	696,134,000.00	647,042,592.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	667,218,400.00	646,312,392.00

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	547,378,900.00	527,661,492.00
210101	Үндсэн цалин	384,407,100.00	369,866,470.00
210102	Нэмэгдэл	147,388,200.00	139,457,404.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,583,600.00	15,995,200.00
210104	Урамшуулал		2,342,418.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,172,300.00	71,409,000.00
210201	Тэтгэврийн даатгал	50,277,200.00	49,801,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,473,800.00	5,401,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,379,100.00	4,321,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,094,700.00	1,080,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,947,500.00	10,804,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,354,000.00	36,284,100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,554,000.00	1,484,100.00
210304	Байрны түрээс	34,800,000.00	34,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,091,000.00	7,570,100.00
210401	Бичиг хэрэг	694,600.00	2,411,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,031,900.00	1,940,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,179,400.00	1,126,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,185,100.00	2,090,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,212,800.00	1,146,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,212,800.00	1,146,800.00
2107	Томилолт, зочны зардал	85,300.00	64,000.00
210702	Дотоод албан томилолт	85,300.00	64,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,924,100.00	2,176,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,747,200.00	
210803	Даатгалын үйлчилгээ	270,400.00	270,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	108,200.00	108,200.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,500.00	33,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,764,800.00	1,764,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,915,600.00	730,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,915,600.00	730,200.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	28,130,400.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	785,200.00	730,200.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	696,134,000.00	647,042,592.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	696,134,000.00	647,042,592.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	696,134,000.00	647,042,592.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	45.00	45.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	36.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	45.00	45.00
650001	Терийн захиргааны албан хаагч (ТЗ)	37.00	37.00
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	52,194,440.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	52,194,440.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,954,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,656,800.00
210101	Үндсэн цалин	36,656,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,585,200.00
210401	Бичиг хэрэг	6,317,200.00
210402	Тээвэр, шатахуун	5,108,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	160,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,712,000.00
210702	Дотоод албан томилолт	3,712,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	240,440.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	240,440.00

213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	240,440.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	52,194,440.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52,194,440.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,094,440.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд түргэн шуурхай,чирэгдэлгүй хүргэх чиг үүргийн хэрэгжүүлдэг байгууллага юм.

Нийгмийн халамжийн бодлогыг ядуурлыг тууштай бууруулахад чиглүүлж, нийгмийн халамж, асаргаа зайлшгүй шаардлагатай иргэдэд хүргэх, ядуурлаас гаргах зорилт дэвшүүлэн ажилласан байна. Энэ зорилтыг хэрэгжүүлэх дараах зорилгуудыг дэвшүүлэн ажилласан байна.

- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээний талаар төрийн бодлогын хэрэгжилтийг хангах, төрийн тусламж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрх,иргэн рүү халамжийн бодлогыг чиглүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд хэвийн оролцох боломж бүрдүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн боловсрол олгох, мэргэжлийн сургалт зохион байгуулах, ажилгүй иргэдийг ажилтай болгох ба ажлын байрыг олноор бий болгох;
- Нийгмийн Халамжийн хууль тогтоомж, ХНХЯ-ны бодлого, ХХҮЕГ-ын чиг үүргийг үндэс болгон олон нийтэд, шударга, чанартай, хүртээмжтэй мэргэжлийн түвшинд хүргэх;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа яеуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон төсвийн байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь аймгийн ХХҮГ-ын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Сүүлийн 3 жилд тус байгууллагын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах *шаардлагагүй* гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18.5 сая төгрөгөөр буюу 9.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0.0
Авлага	102.71	-	-102.7
Бараа материал	5,141.42	5,394.42	253.0
Үндсэн хөрөнгө	197,870.46	179,165.66	-18704.8
Нийт хөрөнгө	203,114.59	184,560.08	-18554.5
Өр төлбөр	1,062.10	-	-1062.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	202,052.48	184,560.08	-17492.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	203,114.59	184,560.08	-18554.5

Дээрх хүснэгтээс харахад авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансанд өөрчлөлт гарсан байна. Тайлант оны эхэнд байсан авлага, өр төлбөрийг барагдуулсан байна.

Бараа материал данс оны эхнээс 0.2 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна. Үндсэн хөрөнгийн дансанд тайлант онд 9.2 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан ба үндсэн хөрөнгөнд 28.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант оны үр дүнгээр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 691.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж төсвийн төслийн саналаас цалингийн зардлыг 15.2 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4.2 сая, хангамж, бараа материалын зардлыг 4.2 сая, тавилга, эд хогшлын зардлыг 1.2 сая төгрөгөөр тус тус бууруулж, томилолтын зардлыг 0.08 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1.1 сая, бусад урсгал шилжүүлгийг 28.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нийт 4.3 сая төгрөгөөр бууруулж 696.1 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 696.1 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 668.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 647.0 сая төгрөг буюу 92.9 хувьтай байгаа нь нийгмийн халамжийн арга хэмжээний зардлыг 41.8 сая, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлыг 7.3 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Нийт хэмнэсэн 49.1 сая төгрөгийн 27.4 сая төгрөг нь 21.7 сая төгрөг нь төвлөрүүлэх шилжүүлэг байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Нийт төсөв	696,134.0	647,042.6	-49,091.4	92.9
1	Нийгмийн халамж	599,415.9	557,588.2	-41,827.7	93.0
1.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	570,500.3	556,858.0	-13,642.3	97.6
1.2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	28,915.60	730.2	-28,185.4	2.5
2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	96,718.10	89,454.40	-7,263.70	92.5
2.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	96,718.10	89,454.40	-7,263.7	92.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь 2022 онд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 0.1 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид олгох төсвөөс 52.1 сая, нийт 52.2 сая төгрөгийн санхүүжилт авч, цалингийн зардалд 36.7 сая, бичиг хэргийн зардалд 6.3 сая, шатахууны зардалд 5.1 сая, шуудан холбоо, интернетийн төлбөрт 0.2 сая, томилолтын зардалд 3.7 сая, нийт 52.0 сая төгрөгийн зарцуулж, 0.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтээр авсан 52.2 сая төгрөг нь халамжийн сангийн үйл ажиллагаатай холбоотой зардлуудыг санхүүжүүлэхээр авсан мөнгө байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 734.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 11.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зарим зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: Цалингийн зардлыг 19.7 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 0.8 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.06 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1.7 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна. Хангамж бараа материалын зардлын 1.5 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан ба бичиг хэргийн зардлыг 1.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь нөлөөлсөн байна. Хангамж бараа материалын бусад зардлуудыг хэмнэлттэй зарцуулсан байна.

Тайлант онд батлагдсан төсвөөс санхүүжилтийг 27.4 сая төгрөгөөр дутуу авсан ба улсын төсөвт 21.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах, программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75%, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 100% байна. Тайлант онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 11.4 сая төгрөгийн 1 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй тул албан шаардлага өгөгдсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчил илрээгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар эхний хагас жилийн баримтыг хүлээн авч түүвэр хийсэн. Завсрын аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад тэвчиж болох зардлын

батлагдсан төсвийн 10 хувь буюу 1320.5 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй, Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 38 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчлийг давтан гаргасан зөрчлүүдэд албан шаардлага өгөгдсөн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийг арилгаагүй, давтан гаргасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	1,320.5	1	1,320.5	100%
Зөвлөмж	-	-	-	-	-
Нийт дүн	1	1,320.5	1	1,320.5	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийг давтан гаргасан эсэх, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж үйл ажиллагаандаа мөрдсөн эсэхийг шалгах нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулгын гүйлгээ гараагүй, 34.5 сая төгрөгийн зөрчилд 2 заалт бүхий зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, бичиг хэрэг, шуудан холбоо томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн төлбөрийн зардлуудаас нийтдээ 34.5 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй бүртгэж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 дэх заалтуудтай нийцээгүй, АОУС-250-д "Санхүүгийн тайланд хууль тогтоомж, дүрэм, журмыг анхаарах", УСНББОУС-1, АДБОУС 200 болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

